



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 22
№20 (1268)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

255. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1283

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

256. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Дугаар 26 1300

257. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 29 1304

258. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 33 1305

259. Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Дугаар 34 1306

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

260. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 02 1308

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

261. Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 02 1314

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:

“13.3.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ.”

2/14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг:

“14.4.Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.”

3/15 дугаар зүйлийн 15.11, 15.12 дахь хэсэг:

“15.11.Энэ хуулийн 12.2.8-д заасан хуулийн төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Ерөнхий сайд тодорхойлж, батлах бөгөөд хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу өргөн мэдүүлнэ.

15.12.Энэ хуулийн 22.1.3-т заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана.”

4/26¹ дүгээр зүйлийн 26¹.2, 26¹.3 дахь хэсэг:

“26¹.2.Тухайн хуульд хуулийн үйлчлэх хугацааг заасан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй болно.

26¹.3.Тухайн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг буцаан хэрэглэхгүй.”

5/29 дүгээр зүйлийн 29.2-29.4 дэх хэсэг:

“29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.

29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.

29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.”

6/30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсэг:

“30.8.Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга ижил нэр томъёог дагаж өөрчлөх шаардлагатай тохиолдолд ижил утгаар ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтад тусгаж болно.”

7/33 дугаар зүйлийн 33.3-33.6 дахь хэсэг:

“33.3.Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд дараах мэдээллийг агуулсан тайлбарыг тусгана:

33.3.1.нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага;

33.3.2.зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай;

33.3.3.нэр томъёо, ухагдахууны үүсэл.

33.4.Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэ хуулийн 33.3-т заасан тайлбарыг шинэчилсэн найруулга бол бүлгээр, нэмэлт, өөрчлөлт бол зүйл, эсхүл хэсэг, заалт тус бүрээр багцлан тусгана.

33.5.Энэ хуулийн 33.3.3-т заасан хуулийн төслийн нэр томьёо, ухагдахууны үүслийг тайлбарлахад холбогдох хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримталж болно.

33.6.Хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, хуулийн төсөл, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үеийн хуралдааны тэмдэглэлийг ашиглаж болох бөгөөд эдгээр нь хуулийн албан ёсны тайлбар болохгүй.”

8/38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг:

“38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.”

9/46¹ дүгээр зүйл:

“46¹ дүгээр зүйл.Хууль тогтоомжийн орчуулга хийх

46¹.1.Засгийн газар шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

46¹.2.Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

46¹.3.Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

46¹.4.Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.”

10/51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг:

“51.4.Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.”

2 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “саналыг” гэсний дараа “бичгээр” гэж, мөн зүйлийн 20.4 дэх хэсгийн “төслөө” гэсний дараа “түүний үзэл баримтлал, танилцуулга,” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалтын “бие даасан санаа” гэсний өмнө “өгүүлбэрүүд нь нэг санааг илэрхийлж байвал нэг хэсэгт тусгах ба” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтын “удирдлага болгох” гэсний дараа “зарчим” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “хуулийн төслийн” гэсний дараа “талаар товч болон дэлгэрэнгүй” гэж, мөн зүйлийн 33.2 дахь хэсгийн “төслийн” гэсний дараа “товч” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “үзэл баримтлал,” гэсний дараа “товч болон дэлгэрэнгүй” гэж, Наймдугаар бүлгийн гарчгийн “БҮРДҮҮЛЭХ,” гэсний дараа “СИСТЕМЧЛЭХ,” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “Засаг дарга” гэсний дараа “, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бусад байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

2/7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг:

“7.3.Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар анхдагч хууль болон шинэчилсэн найруулга гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.

7.4.Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулна.”

3/12 дугаар зүйлийн 12.2.11 дэх заалт:

“12.2.11.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-т заасан баримт бичгийг батлах тухай;”

4/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

“14.3.Энэ хуулийн 14.2.1-д заасан үндэслэл, шаардлагыг хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөлд тодорхой тайлбарлаж тусгана. Хууль тогтоомжийн төсөл нь хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцэж байгаа эсэхийг үндэслэл, шаардлагад тодруулна.”

5/15 дугаар зүйлийн 15.7.1 дэх заалт:

“15.7.1.эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцаа;”

6/30 дугаар зүйлийн 30.2, 30.3 дахь хэсэг:

“30.2.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд хууль зүйн нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тодорхойлох, жигдлэн хэвшүүлэх, нэр томъёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хууль зүйн хэлний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.3.Зөвлөл нь энэ хуулийн 30.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол хэлний тухай хуульд заасан Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран ажиллаж, тодруулга авч болно.”

7/38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг:

“38.2.Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл болон энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.”

8/45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг:

“45.3.Энэ хуулийн 45.1-д заасан хууль тогтоомжийн цахим санг Хууль зүйн үндэсний хүрээлэн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд хариуцан байршуулах бөгөөд санг бүрдүүлэх, ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

9/49 дүгээр зүйл:

“49 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байгууллага

49.1.Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

49.2.Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

49.3.Энэ хуулийн 15.7.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ хэрэгжүүлнэ.

49.4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх буюу хамтран ажиллаж болно.

49.5.Хүрээлэнгийн үйл ажиллагааны дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

49.6.Хүрээлэн энэ хуулийн 15.7.1-д зааснаас бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ болон энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4-т заасан судалгааг захиалгаар гэрээний үндсэн дээр хийж болно.

49.7.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.”

10/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно.”

11/52 дугаар зүйл:

“52 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг хэлэлцэх

52.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,

хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

52.2.Улсын Их Хурал хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлахдаа тухайн хууль тогтоомжийн ач холбогдол, зохицуулалтын онцлогийг харгалзан шаардлагатай бол уг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дүнг танилцуулах хугацаатай үүргийг Засгийн газарт өгч болно.”

4 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “, түүнчлэн” гэснийг “болон” гэж, 12 дугаар зүйлийн 12.2.8 дахь заалтын “Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний” гэснийг “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах” гэж, мөн зүйлийн 12.2.17 дахь заалтын “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹.1-д” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтын “үүсч” гэснийг “үүсэж” гэж, мөн зүйлийн 14.2.4 дэх заалтын “хуульд” гэснийг “шинэчлэн найруулах,” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “асуудал” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтын “хуульд” гэснийг “хууль болон хууль зүйн бодлогод” гэж, мөн зүйлийн 21.10 дахь хэсгийн “санал, дүгнэлтийн төслийг” гэснийг “дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн 21.12 дахь хэсгийн “саналаа” гэснийг “санал, дүгнэлтээ” гэж, мөн зүйлийн 21.13 дахь хэсгийн “эрх” гэснийг “хууль” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан” гэснийг “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалтын “нэг” гэснийг “цөөн” гэж, мөн зүйлийн 28.2.5 дахь заалтын “нэгтгэж болно.” гэснийг “нэгтгэх.” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “үзэл баримтлалтай” гэснийг “үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой” гэж, мөн зүйлийн 29.1.8 дахь заалтын “журам;” гэснийг “журмыг тусгасан байх.” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “хэлээрх” гэснийг “хэл дээрх” гэж, 38 дугаар зүйлийн 38.4-38.8 дахь хэсгийн дугаарыг “38.5-38.9” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “үүрэг бүхий холбогдох бусад” гэснийг “чиг үүрэг бүхий” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.10 дахь заалтын “товьёг” гэснийг “товьёг” гэж, мөн заалтын “38.6-д” гэснийг “38.7-д” гэж, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “72 цагийн дотор” гэснийг “ажлын гурван өдрийн дотор” гэж, Аравдугаар бүлгийн гарчгийн “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,” гэснийг “ҮР ДАГАВРЫН” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Төрийн захиргааны төв байгууллагын саналд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурсан байна.” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.10 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийг



хөгжүүлэх үндсэн чиглэл,” гэснийг, мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн “Онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд 72 цагийн дотор саналаа хүргүүлнэ.” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийн “үндэсний аюулгүй байдлын үүднээс” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг, 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.2.4, 12.2.12, 12.2.13, 12.2.14 дэх заалтыг, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг, 26 дугаар зүйлийг, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.1.11 дэх заалтыг, 50 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Индрикс Фолс оа Нолл

Ажлын үндэсний байгууллага

Ажлын үндэсний байгууллага 2023.09.06

Урьдчилсан гэрээний үндсэн дээр
Хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага:

«...»-ийн үндсэн үндэсний байгууллага...
Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага:

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...
Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...
Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...
Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага:

Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...
Төлөөлөгчид хүндэтгэсэн ажлын үндэсний байгууллага...

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын хянан шалгах
түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн
банкнаас санхүүжүүлсэн төсөл,
хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл
олголт, эргэн төлөлтийн явцын талаар
хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурал анхны Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг улс орон даяар нээлттэй зохион байгуулсан нь парламентын хянан шалгах тогтолцоо бүрдэхэд чухал үүрэг гүйцэтгэж, Монгол Улсад төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, парламент нь ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах, төр ба ард түмний итгэлцлийг батжуулах, нийгмийн шударга ёсыг тогтоох, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хөшүүрэг болсныг сайшаан тэмдэглэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороог байгуулах үндэслэл, түр хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээний хүрээ хязгаарыг тодорхой болгох, түр хорооны гишүүнээр ажиллах тохиолдолд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан тодорхойлж, гэрч, хянан шалгагч, шинжээч нарыг томилох, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, нотлох баримттай танилцах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

2.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг ба мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын онцлог, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Б.Энхбаяр/-нд даалгасугай.



3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлж, Хөгжлийн банкийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцад хийсэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтны хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Хууль зүйн байнгын хороо /Б.Энхбаяр/-нд тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian Folio_04 УИХ НХТГ 04 ДТ 29

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠰᠤᠨ ᠲᠦᠰᠡᠯ ᠪᠤᠴᠤᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤ

ᠲᠤᠰᠤᠨ ᠲᠦᠰᠡᠯ ᠪᠤᠴᠤᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠰᠤᠨ ᠲᠦᠰᠡᠯ ᠪᠤᠴᠤᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠰᠤᠨ ᠲᠦᠰᠡᠯ ᠪᠤᠴᠤᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠲᠤᠰᠤᠨ ᠲᠦᠰᠡᠯ ᠪᠤᠴᠤᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналыг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон нийт гишүүний олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolia Folio_02 Урдд Ногдк 02 Docx(48k)

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ ᠲᠤᠮᠤᠭᠠᠰᠤ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн хэлний зөвлөл Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд ажиллах болсонтой холбогдуулан хууль тогтоомжийн системчлэл, хуулийн лавлагаа мэдээлэл, сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэн, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнг нэгтгэн зохион байгуулж Улсын Их Хурлын дэргэд шилжүүлэн ажиллуулсугай.

2.Хүрээлэнг нэгтгэн зохион байгуулахтай холбогдуулан зохих шийдвэрийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж, шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Б.Энхбаяр/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 29.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, үйлчилгээг боловсронгуй болгож, сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайханд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 404 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Т.АЮУРСАЙХАН



Засгийн газрын 2023 оны 01 дүгээр
сарын 04-ний өдрийн 02 дугаар
тогтоолын хавсралт

ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ УДИРДАХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өрхийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх)-г удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагаанд энэ журмыг баримтална.

1.2.Мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл хариуцагч нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байна.

1.4.Мэдээллийн нэгдсэн сан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан аргачлал (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу бүртгэгдсэн өрх (өрхийн гишүүн-иргэн)-ийн талаарх мэдээллээс бүрдэх бөгөөд мөн хуулийн 3.1.11-д заасны дагуу өрхийг амьжиргааны түвшингээр эрэмбэлж оноо өгөх боломжтой байна.

Хоёр.Мэдээллийн нэгдсэн санг удирдах, зохион байгуулах

2.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах, сангаас мэдээлэл солилцох үйл ажиллагааг ерөнхий удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангах, мэдээллийг тухай бүр шинэчлэх үүрэг хүлээнэ.

2.3.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхдээ аргачлалд тусгагдсан зарим шаардлагатай мэдээллийг доор дурдсан төрийн мэдээллийн сангаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.3-т заасан төрийн мэдээлэл солилцооны систем (цаашид “үндсэн систем” гэх)-ээр дамжуулан мөн хуулийн 18.10-т заасан журмын дагуу авна:

2.3.1.иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан;

2.3.2.эд, хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан;

2.3.3.хүн ам, өрхийн мэдээллийн сан;

2.3.4.зээлийн мэдээллийн сан;

2.3.5.мал, тэжээвэр амьтны тооллогын мэдээлэл бүхий мэдээллийн сан;

2.3.6.боловсролын салбарын мэдээллийн сан;

2.3.7.нийгмийн даатгалын мэдээлэл бүхий мэдээллийн сан;

2.3.8.нийгмийн халамжийн мэдээлэл бүхий мэдээллийн сан;

2.3.9.эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сан;

2.3.10.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан;

2.3.11.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан;

2.3.12.улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сан;

2.3.13.цахилгааны хэрэглээний мэдээлэл бүхий мэдээллийн сан;

2.3.14.төрийн албан хаагчийн мэдээлэл бүхий мэдээллийн сан;

2.3.15.бусад.

2.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг доор дурдсанаар шинэчилнэ:

2.4.1.энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангийн мэдээллийг өмнөх оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрүүдэд хамаарах хугацаагаар тооцож, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан бүрэн;

2.4.2.мэдээллийн эзний төрсөн, нас барсан, үрчилсэн талаарх мэдээллийг энэ журмын 2.3.1-д заасан мэдээллийн сангаас, өрхийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийн талаарх мэдээллийг мөн журмын 2.3.3-т заасан мэдээллийн сангаас тухай бүр;

2.4.3.мэдээллийн эзний хүсэлтийг үндэслэн аргачлалд тусгагдсан мэдээллийг тухай бүр.



2.5.Мэдээллийн эзэн энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангаас авсан мэдээлэл зөрүүтэй гэж үзсэн бол тухайн мэдээлэл хариуцагчид мэдэгдэж, зохих журмын дагуу засварлуулах, мөн журмын 2.4.3-т заасны дагуу хүсэлтийг гарган мэдээллийн нэгдсэн сан дахь өөрийн мэдээллийг шинэчлүүлж болно.

2.6.Энэ журмын 1.3-т заасан мэдээлэл хариуцагч дараах үүрэгтэй байна:

2.6.1.энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангаас үндсэн системээр дамжуулан мэдээлэл хүлээн авах сервисийг хөгжүүлэх;

2.6.2.мэдээллийн нэгдсэн сангаас үндсэн системээр дамжуулан мэдээллийг нийлүүлэхэд шаардлагатай сервисийг хөгжүүлэх;

2.6.3.аргачлалд тусгагдсан өөрийн байгууллагад хамаарах холбогдох мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулах, үнэн зөв байдалд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, шинэчлэх;

2.6.4.аргачлалыг хэрэгжүүлэх программ хангамжийг хөгжүүлэх.

2.7.Энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч нь дараах үүрэгтэй байна:

2.7.1.хариуцсан мэдээллийн сан дахь холбогдох мэдээллийг үндсэн системд дараах хугацаанд нийлүүлнэ:

2.7.1.1.энэ журмын 2.4.1-д заасны дагуу шинэчлэх мэдээллийг дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

2.7.1.2.энэ журмын 2.4.2, 2.4.3-т заасны дагуу шинэчлэх мэдээллийг сар бүрийн 10-ны өдрийн дотор.

2.7.2.энэ журмын 2.7.1-д заасны дагуу үндсэн системд мэдээлэл нийлүүлэхэд шаардлагатай сервисийг өөрийн систем талд хөгжүүлэх;

2.7.3.энэ журмын 2.7.1-д заасан нийлүүлж буй мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, шинэчлэх.

2.8.Мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл болон уг санд үндэслэн үзүүлж байгаа үйлчилгээний талаарх өргөдөл, гомдлыг доор дурдсанаар гаргана:

2.8.1.аргачлалтай холбоотой асуудлаар Үндэсний



статистикийн хороо, эсхүл нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.8.2.энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангаас авсан мэдээлэлтэй холбоотой асуудлаар тухайн мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагчид;

2.8.3.мэдээллийн нэгдсэн санг ашиглан үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн үйлчилгээг үзүүлж байгаа төрийн байгууллага, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүнд.

2.9.Энэ журмын 2.8-д заасны дагуу өргөдөл, гомдлыг хүлээн авсан этгээд холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэнэ.

2.10.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь мэдээллийн нэгдсэн сантай холбоотой асуудлаар өрх, иргэнийг мэдээллээр хангаж ажиллана.

Гурав.Мэдээллийн нэгдсэн санг ашиглах

3.1.Төрийн байгууллага нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу мэдээллийн нэгдсэн санг ашиглана.

3.2.Мэдээллийн эзэн нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж байгаа өөрт хамаарах мэдээллийн хуулбарыг гаргуулан авч болно.

Дөрөв.Мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдал

4.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ журмын 1.3-т заасан мэдээлэл хариуцагч нь мэдээллийн нэгдсэн сангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.Мэдээллийн нэгдсэн сангийн аюулгүй байдлыг хангахдаа Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7.1-д заасан нийтлэг журам болон мөн хуулийн 7.2-т заасан кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журмыг дагаж мөрдөнө.

4.3.Мэдээлэл хариуцагч нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.6-д заасан эрсдэлийн үнэлгээг хуульд заасан хугацаанд хийлгэнэ.

4.4.Мэдээллийн нэгдсэн санг мэдээлэл хариуцагч болон Үндэсний дата төвд байршуулах бөгөөд нөөц болон толин серверийн дэд бүтэцтэй байна.



4.5.Мэдээллийн нэгдсэн санд холбогдож ажиллаж байгаа программ хангамжууд болон нууцлалын шифрлэлт (SSL) нь албан ёсны эрхтэй байна.

4.6.Мэдээллийн нэгдсэн санд хийсэн үйлдэл тус бүрээр бүртгэлийн түүх үүсгэж хадгална.

Тав.Бусад

5.1.Энэ журмын 2.3-т заасан мэдээллийн сангаас авсан мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч хариуцна.

5.2.Мэдээллийн нэгдсэн санг ашиглах үүрэг бүхий ажилтан албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүргийг хүлээнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2023 оны 05 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

**Монгол Улсын шүүхийн тухай хууль,
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 17.40 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Г.Баясгалан, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Ариунболд, П.Ундрах-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар оролцов.

Уг хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалт; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь; мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэгт “Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана.” гээд 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 **дугаар зүйлийн** 123.2 дахь хэсэгт “Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана.” гээд 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 **дүгээр зүйлийн** 1 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно.” гээд 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, мөн зүйлийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...”, Дөчин **есдүгээр зүйлийн** 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, **Тавьдугаар зүйлийн** 1 дэх хэсгийн “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 2 дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ... Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.”, **Далдугаар зүйлийн** 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан шүүхийн шүүн таслах ажиллагааны үндсэн тогтолцоо нь хэрэг маргааныг анхан, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх гурван үе шатнаас бүрддэг бөгөөд дээрх гурван шатны хүрээнд аливаа хэрэг, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж хүн,



хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээх, цаашлаад эрүүгийн хэргийн тухайд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг тогтоох, цагаатгах, ял оногдуулах үндсэн чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Хэрэг маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэх нь Улсын дээд шүүхийн онцгой бүрэн эрх бөгөөд үүнийгээ бусад шатны шүүхтэй хуваалцдаггүй. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхийн үндсэн чиг үүрэг нь шүүхийн хяналтын зорилготой бөгөөд улсын хэмжээнд аливаа хэрэг, эрх зүйн маргааныг хэргийн оролцогч талуудын гомдлоор эцэслэн шийдвэрлэдэг. Тиймээс Улсын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллагын хувьд доод шатны шүүх буюу анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг аль алийг нь хяналтын журмаар хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй гэж үзнэ.

Гэтэл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтад Улсын дээд шүүх нь зөвхөн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг л хянахаар хуульчилсан нь Үндсэн хуулиар Улсын дээд шүүхэд олгосон “доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” бүрэн эрхэд нийцэхгүй байна.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалт, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэсэн үндэслэлээр зөвхөн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар хянана гэж заасан нь анхан болон давж заалдах шатны шүүх хууль хэрэглээний зөрүүгүй буюу анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн тохиолдолд шийдвэр, магадлалыг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан үзэх боломжгүй. Тодруулбал, хэргийн оролцогчид нь дээрх тохиолдолд л хууль хэрэглээний асуудлаар шүүхийн хяналтын шатанд гомдол гаргах болж байна. Үүнээс үүдэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хууль хэрэглээний хувьд зөрүүгүй адил гарсан хэдий ч хоёулаа хууль зөрчсөн, эсхүл хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн бол уг асуудлаар хэргийн оролцогчид гомдол гаргах эрхгүй, гаргасан ч хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх боломжгүй байх үр дагаврыг үүсгэж болзошгүй юм. Энэхүү үр дагавар нь иргэний шүүхэд гомдол мэдүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхэд нийцэхгүй гэж үзэх үндэслэл болж байна.

Шүүх эрх мэдлийн үндсэн зорилго нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээн тогтоохын тулд нийгмийн

харилцааг зохицуулсан хуулийг хэрэглэж хэрэг, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд оршдог. Тиймээс шүүх эрх мэдэл нэгдмэл, нэг үндсэн тогтолцоотой, дээд шүүх нь хяналтын шатны шүүх мөн бол иргэний шүүхэд мэдүүлэх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх нь материаллаг хууль хэрэглээний гомдолтой асуудлаар шүүхийн бүх шатанд гомдол гаргаж хянуулснаар хангагдах юм.

Үүнээс гадна доод шатны шүүхүүд хуулийг зөрүүтэй хэрэглээгүй тохиолдолд материаллаг хууль хэрэглээний хувьд хууль хэрэглээний маргаантай асуудлаар дээд шүүхэд гомдол гаргах боломжгүй, дээд шүүх уг асуудлыг хүлээн авч хянан шийдвэрлэх боломжгүй байгаа нь шүүхийн үндсэн тогтолцооны талаарх Үндсэн хуулийн зарчимд үл нийцэж байна.

3.Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим байдаг. Энэ нь шүүх эрх мэдэлд шүүгч гагцхүү хуульд захирагдана гэсэн зарчмаар илэрдэг. Үүний дагуу шүүх нь “шүүх эрх мэдэл”-ийг хэрэгжүүлэхдээ хуулийг дээдлэн, захирагдаж тодорхой хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэдэг. Харин шүүх эрх мэдэл гэдэг нь аль нэг шатны шүүх, шүүхүүд биш бөгөөд Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан шүүхийн үндсэн тогтолцоо. Гэтэл шүүхийн анхан болон давж заалдах шатанд шийдвэр нь хууль хэрэглээний хувьд адил тохиолдолд уг шийдвэрүүдийг хууль зөрчсөн гэж үзэж байсан ч хэргийн оролцогчид хяналтын шатны шүүхэд тухайн хууль хэрэглээний асуудлаар гомдол гаргах эрхгүй болжээ. Энэ нь Улсын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллага байх Үндсэн хуулийн заалтад нийцэхгүй гэж үзэж байна.

4.Анхан болон давж заалдах шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэр, магадлал нь хуульд нийцээгүй гэж үзвэл хэргийн оролцогчид уг асуудлыг хяналтын шатны шүүхэд гомдол гаргах байдлаар хянуулах эрхтэй байдаг. Энэ нь шүүх эрх мэдлийн үндсэн тогтолцооны нэгдмэл байдал бөгөөд дагнасан шүүхийн тухайд түүний шийдвэр үйл ажиллагаа нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур үл байх зарчим юм. Өөрөөр хэлбэл, анхан болон давж заалдах шатны шүүхүүд хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль хэрэглээний зөрүүтэй, зөрүүгүй хэрэглэсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн шийдвэрийг хуульд нийцээгүй гэж үзвэл хэргийн оролцогчид хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж хянуулах нь шүүхийн үндсэн тогтолцоо ажиллаж байгаа нэг илэрхийлэл юм.

Тиймээс анхан болон давж заалдах шатны шүүхүүд хууль хэрэглээний хувьд адил буюу анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн нь тэдгээр шүүхийн шийдвэрийг шүүхийн эцсийн шийдвэр гэж үзэх боломжгүй. Нэгэнт шүүхийн үндсэн тогтолцоог анхан, давж заалдах, хяналтын шат гэж Үндсэн хуулиар



тодорхойлсон тул анхан болон давж заалдах шатны шүүхүүд хууль хэрэглээний хувьд адил (зөрүүгүй) байвал гомдол гаргах эрхгүйгээр эцсийн байх агуулгаар хуульчлан тогтоосон нь шүүх эрх мэдэл нь үндсэн тогтолцоотой нэгдмэл байх зарчимд үл нийцэж байна. Энэ нь дагнасан шүүхийн хувьд мөн хамааралтай.

5. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.6 дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэснийг процессын хуулиудад тусгаснаас үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхүүд Улсын дээд шүүхийн тайлбарын дагуу хууль хэрэглэн шийдвэрлэсэн бол хяналтын шатанд гомдол гаргах боломжгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна гэсэн нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарласан дээд шүүхийн шийдвэрт үл хамаарах ба хэрэг маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт л хамаатай гэж үзнэ. Учир нь Үндсэн хуулийн мөн хэсэгт Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ гэсэн байдаг.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан Улсын дээд шүүхийн тайлбар (шийдвэр) нь хуульд нийцээгүй, учир дутагдалтай гэж үзвэл Үндсэн хуульд заасанчлан хуулийг дагаж биелүүлнэ. Тиймээс хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд хяналтын шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалт нь шүүгч гагцхүү хуульд захирагдах, дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлэх Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байна.

6. Шүүхийн хяналтын шатны үндсэн зорилго нь шүүхийн анхан шат, давж заалдах шатанд хууль зөрчигдөхөөс, алдаа гарах, шүүхийн шийдвэр, үйл ажиллагааны улмаас иргэн хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд оршдог. Энэ нь шүүхийн шийдвэр тухайн маргаантай асуудалд эцсийн болдогтой холбоотой.

Үүнээс гадна шүүхийн хяналтын шат нь Монгол Улсад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгоход оршдог. Хууль хэрэглээний нэгдмэл байдал гэх ойлголт нь тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хамааралтай биш ба нийт шүүхүүдэд хамаатай. Харин тэрхүү зөрүүг арилгах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлын зарчим юм.

Түүнчлэн хууль хэрэглээний нэгдмэл байдал нь зөвхөн шүүхэд хамааралтай гэж үзэх нь учир дутагдалтай. Энэ нь хууль гүйцэтгэх, хууль сахиулах, иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд ч мөн хамаатай гэж үзэж болно. Нэгэнт тодорхой эрх зүйн маргааныг хууль хэрэглэн шүүх эрх мэдэл эцэслэн шийдвэрлэсэн бол түүнтэй адил өөр тохиолдолд дахин хууль зөрчих шаардлагагүй ба шүүхийн шийдвэрлэсэн хууль хэрэглээний дагуу асуудалд хандах ёстой. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэрийг бүх шүүхүүд заавал биелүүлэхээс гадна аливаа бусад этгээд ч мөн заавал биелүүлнэ гэж заасан байдаг.

Гэтэл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад дээд шүүхийн хяналтын шатны чиг үүргийг зөвхөн “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах,” гэж явцуу байдлаар хуульчилсан нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэсэнд нийцэхгүй байна.

Тиймээс Монгол Улсын шүүхийн тухай хууль эрүү, иргэн, захиргааны процессын хуульд заасанчлан анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн үндэслэлээр хэргийн оролцогчид шүүхийн хяналтын шатанд гомдол гаргах эрхтэй байгаа нь учир дутагдалтай, Үндсэн хуульд нийцэхгүй гэж үзэж байна.” гэжээ.

Хоёр.Монгол Улсын иргэн П.Ундрах-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад зааснаар анхан болон давж заалдах шатны шүүх нь Эрүүгийн хуулийг зөвхөн буруу хэрэглэсэн биш харин “зөрүүтэй” хэрэглэсэн тохиолдолд тухайн хэргийг Улсын дээд шүүх хянахаар заажээ. Өөрөөр хэлбэл, анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн өөр өөр зүйлийг баримталж шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэр, магадлалыг хянах ба харин анхан болон давж заалдах шатны шүүх хууль хэрэглээний хувьд адилхан шийдвэрлэсэн буюу ижил шийдвэр гаргасан тохиолдолд хянах эрх хэмжээгүй болжээ.



Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт Эрүүгийн хууль хэрэглээний өөрчлөлт оруулаагүй тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт “зөрүү” гараагүй гэж үзэж Улсын дээд шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хянах эрхгүй. Энэ тохиолдолд давж заалдах шатны шүүхийн магадлал эцсийн шийдвэр болох юм. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэснийг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд 2 дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалт, мөн өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өмнөх хуульд байсан “шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” гэснийг “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэж өөрчилж Улсын дээд шүүхийн эрх хэмжээг зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн зөрүүг арилгах хүрээнд хязгаарлажээ.

Анхан шатны шүүх нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж хэргийг шийдвэрлэж, давж заалдах шатны шүүх түүнийг залруулалгүйгээр хэвээр үлдээсэн тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд зөрүү гарахгүй бөгөөд үүгээр иргэний хяналтын журмаар Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрх хязгаарлагдаж, давж заалдах шатны шүүхийн магадлал эцсийн шийдвэр болох ба энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ...” иргэний үндсэн эрхийг хөндөж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ...” үүрэг зөрчигдөхөд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтэд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ...” эрхийг Монгол Улсын иргэнд олгохдоо ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй ба шүүхийн шийдвэрт давж заалдах иргэний эрхийг зөвхөн давж заалдах шатны шүүхэд хандах

эрхээр хязгаарлахгүйгээр аливаа шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхээр нь хянуулах эрх гэж Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 5-д зааснаар ойлгохоор байна. ...” гэжээ.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Гурав.Монгол Улсын иргэн М.Амарнасаа Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, тус хуулийн 3 дугаар зүйлд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.” гээд 3/“172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана.” 172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн; 172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн; 172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн; 4/“173.4.Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.” гэж өөрчлөн найруулж хуульчилжээ.

Дээр дурдсан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн



шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний хэрэг маргаан Улсын дээд шүүхээр хянагдаад анхан болон давж заалдах шатны шүүхүүд хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэсэн үндэслэлээр аль аль нь хүчингүй болж тухайн шийдвэр, магадлалаар шийдвэрлэснээс өөрөөр шийдвэрлэгдэх, эсхүл анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах зэрэг тохиолдол багагүй гардаг. Тухайлбал, Улсын дээд шүүхийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн статистикийг тус шүүхийн цахим хуудаснаас харахад сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг аль алиныг нь хүчингүй болгосон 993 хэрэг байгаа гэсэн үзүүлэлт гарсан байх бөгөөд энэ нь 5 жилийн хугацаанд Улсын дээд шүүхээр хянагдсан нийт хэргийн 14.3 хувь байна. Түүнчлэн дээрх хугацаанд 905 шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан байгаа нь нийт хянагдсан хэргийн 13.5 хувь байна. Энэ нь анхан болон давж заалдах шатны шүүхүүд аль аль нь хуулийг зөрүүтэй хэрэглээгүй хэдий ч хуулийг буруу тайлбарлаж хэрэглэх, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий зарчмыг зөрчсөн шийдвэр гаргадаг гэдгийг харуулж байна.

Иймд тус заалт нь анхан болон давж заалдах шатны шүүхийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна гэж үзсэн тохиолдолд иргэн, хуулийн этгээд хяналтын журмаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан гэж үзэхээр байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.2 дахь заалтад “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;” гэсэн нь Улсын Их Хурлаас шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргаж болно, гэхдээ уг зөрчил нь ноцтой зөрчил байх, түүнчлэн тэр нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн тохиолдолд гомдол гаргах эрхтэй байхаар хуульчилсан нь дээр дурдсан хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг бүрдүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэг хүлээсэн төрийн үйл ажиллагааны зарчмыг зөрчсөн байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасан бөгөөд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг

өчүүхэн төдий ч зөрчихгүйгээр хуулиар тогтоосон журмыг чанд баримтлан ажиллах явдал нь Үндсэн хуулиар тогтоосон үзэл санаа, агуулга зарчимд нийцнэ гэж ойлгож байна. Гэтэл энэ мэтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа зөрчил гаргахыг зөвшөөрсөн, уг зөрчил нь шүүхийн шийдвэрт нөлөөлөөгүй тохиолдолд гомдол гаргах эрхгүй байхаар хуульчилж байгаа нь Үндсэн хуулийн агуулга, зарчимтай зөрчилдөж байна.

3.Мөн хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж хуульчилжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэг болон дээр дурдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зөвхөн Улсын дээд шүүхээс тайлбарласан хуулийг шүүх хэрэглэхээр заагаагүйгээс гадна Улсын дээд шүүх Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхтэй хэдий ч бүх хуулийг тайлбарлах боломж байхгүй бөгөөд амьдрал дээр зөрүүтэй хэрэглэгдэж байгаа хуулийг Улсын дээд шүүхээс нэг мөр, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байдаг бөгөөд Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшлах ч тохиолдол байж болно. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.” гэж хуульчилсан.

Гэтэл хууль тогтоогч дээр дурдсаны дагуу явцуу байдлаар хуульчлан оруулснаараа зохигч, гуравдагч этгээдийн шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан эрхийг эдлэх баталгааг бүрдүүлэх үүргээ умартсан байна. Нөгөө талаас хууль хэрэглээний практикт тогтсон ойлголтыг эвдэж, Улсын дээд шүүхээс бусад онолын болон хэл зүйн тайлбаруудыг үгүйсгэх, улмаар хуулийг өөр өөрийнхөөрөө дур мэдэн тайлбарлах, хууль хэрэглээний ойлгомжгүй байдлыг бий болгох, Үндсэн хуулиар бататгасан үнэт зүйлс алдагдах үр дагаврыг үүсгэх боломжтой байдлаар хуульчилсан гэж үзэж байна.

4.Дээрх хуулийн 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсгийг өөрчлөн найруулж “Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.” гэж заасан нь тус хуулийн 172 дугаар зүйлд заасан гомдолд тавигдах шаардлагыг орхигдуулан зөвхөн гомдол гаргах хугацаа, улсын тэмдэгтийн хураамж төлөх шаардлагыг хамруулан өөрчлөн найруулсан нь шүүхээс хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрхэх, түүнчлэн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналтын журмаар гомдол гаргаж буй этгээдэд гомдлыг нь шүүх хүлээж авах журам нь

тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгосноороо иргэдийнхээ өмнө хүлээсэн эрх зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг алдагдахад хүрч, улмаар Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх үр дагавар үүсгэж байна.

Иймд дээр дурдсан үндэслэлийг хянан үзэж, Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтад “Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх.” гээд 25.7.5.а-д “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, 25.7.5.б-д “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;”, 25.7.5.в-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.” гэж заасан. Мөн хууль хоорондын нийцлийг хангаж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн бол, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол давж заалдах шатны шүүхийн магадлалыг Улсын дээд шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэхээр тус тус зохицуулсан. Энд дурдсан маш тодорхой үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянадаг болж буй нь Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах Үндсэн хуулийн гол чиг үүргээ хэрэгжүүлдэг болоход чиглэнэ гэж хууль тогтоогч үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасанчлан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн хүн уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй гэсэн нь иргэн, хуулийн этгээд зөрчигдсөн гэж үзсэн эрхээ хамгаалуулахаар анхан болон давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрх нь нээлттэй байгаагаар хангагддаг. Хууль тогтоогч хяналтын шатны шүүхэд хандах үндэслэлийг нарийвчилсан шалгуураар тодорхойлж өгсөн нь тэрхүү эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг хөндөөгүй.

Иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх нь хуулийн цогц зохицуулалтаар хангагддаг эрх юм. Анхан шатны шүүхийн шийдвэрт үйл баримтын болон хууль хэрэглээний алдаа гарсан тохиолдолд давж заалдах шатны шүүхэд энэ талаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжийг шүүхийн тухай болон процессын хуулиудаар бүрэн хангаж өгсөн. Улсын дээд шүүхийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал нь анхан шатны болон давж заалдах шатны бүхий л хэрэг маргаан руу орж шийдвэрлэх бус, харин Монгол Улсад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах явдал юм. Монгол Улсын шүүхийн тухай хууль, түүнтэй холбогдуулан процессын хуулиудад оруулсан зохицуулалт нь анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн чиг үүргийг Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын туршлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн зохистой хуваарилан зохицуулж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлын баталгааг олон талаар хангаж буй тул шударгаар шүүлгэх эрхийг хангахад чиглэсэн чухал шинэчлэл болсон. Дээд шүүх бүх хэрэг маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэдгийг хязгаарлаж, зөвхөн хуулийн хэрэглээний хамгийн ноцтой асуудлуудыг хуульд зааснаар тодорхой шийдэхээр хуульчилсан нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг зөрчөөгүй юм. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал гэдэг бол шүүх эрх мэдэл бүхэлдээ бусад эрх мэдлүүдээс хараат бус байх утгаас гадна, шүүхийн тогтолцоо дахь “дотоод хараат бус байдал”-тай салшгүй холбоотой юм.

... Дээд шүүхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн бүх магадлалыг хяналтын журмаар хянан шийдвэрлэх эрхийг олгох тохиолдолд доод шатны шүүх болон түүний шүүгчдийг шатлан захирах, хянах үр дагавар үүсэх магадлалтай. ... Ийм өргөн эрх бүхий Дээд шүүхийн гаргасан тайлбар, зөвлөмж, сургалтын агуулга, шийдвэр бичих аргачлалд ягштал захирагдахгүй бол анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид чөлөөлөгдөх, эсхүл ийм айдастайгаар ажиллаж, шүүгчийн дотоод хараат бус байдлыг зөрчих эрсдэлтэй гэж хууль тогтоогч үзсэн. Мөн бүх шатны шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтлэх замаар тэдгээрийн улс орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангах, дээд шатны шүүхэд гомдол гаргах үндэслэл бүхий журамтай байх нь шүүгчийн хараат бус байдлыг эрсдүүлэхгүйгээр хуулийн тайлбар, хэрэгжилтийг тууштай, нэгдмэл болгоход хангалттай гэж үздэг.

Судалгаа (Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим зохицуулалтад холбогдох харьцуулсан судалгаа)-аас үзэхэд бусад орнуудын Дээд шүүх нь анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн бүх хэрэг маргааныг хянан хэлэлцдэг эсэх асуудал нь шүүхийн тогтолцоо болон эрх зүйн тогтолцооноосоо шалтгаалж харилцан адилгүй байна. Судалгаанд хамрагдсан ихэнх улсын Дээд шүүх нь анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэрэг маргааныг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хяналтын

шатны журмаар хэлэлцдэг бөгөөд үүнийгээ хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон шүүхийн тухай хуульдаа тусгайлан зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, Дээд шүүхэд ямар тохиолдолд хандаж гомдол гаргах, түүнийг нь хүлээн авах үндэслэл, хүлээн авахгүй байх тохиолдлуудыг хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа тусгайлан нарийвчилж зохицуулж өгсөн нь Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ хязгаарыг тодорхой болгож, хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл нь болдог байна. Тухайлбал, ХБНГУ-ын эрүүгийн процессын хуулийн 337 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэр зөвхөн материаллаг буюу процессын хуулийг зөрчсөн бол хянана. Хууль зөрчсөн гэж эрх зүйн хэм хэмжээ хэрэглээгүй буюу буруу хэрэглэснийг ойлгоно гэж тодорхойлжээ. Түүнчлэн зарим улсад дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл нь хууль хэрэглээний утгаар, хуулийн нэг мөр хэрэглээг тодруулах, өмнө шийдвэрлэгдэж байгаагүй маргааныг хянуулах хүрээнд хязгаарлагдаж байгаа нь анхаарал татаж байна. Их Британийн хувьд хэрэг хянан шийдвэрлэсэн урьдын туршлагыг эш үндэс болгон шүүх үнэлэлт өгдөг нөхцөл байдал нь энэхүү зохицуулалттай холбоотой гэж ойлгогдохоор байна. Мөн зарим улсын Дээд шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар хууль тайлбарлах, хуулийг нэг мөр хэрэглэх талаар тайлбар гаргадаг ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон гаргасан шийдвэр нь эрх зүйг хөгжүүлэх, шүүхийн нэгдсэн практикийг төлөвшүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

Хууль тогтоогч нь Улсын дээд шүүх мөн чанараараа давж заалдах шүүх мөн эсэх, (тэрээр зөвхөн доод шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг л авч үздэг пакт буюу баримтуудыг авч үздэггүй, зарчмын хувьд хэргийг шүүхэд буцаадаг) эсхүл баримтууд болон хуулийг хэрэглэсэн байдлыг авч хэлэлцэж эцсийн шийдвэр гаргадаг Улсын дээд шүүх байгууллага уу гэдгийг тодруулах зорилгоор ийнхүү хуульчилсан бөгөөд Улсын дээд шүүхийн мөн чанарыг тодруулж өгсөн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 1 дэх заалтад “... хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоодог бөгөөд шүүхийн үйл ажиллагааны үндэст Улсын дээд шүүхэд гомдол гаргах үндэслэл, журам багтах учраас

уул үндэслэл, журмыг хэрхэн хуульчлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал бөгөөд Үндсэн хуулийн зөрчил биш юм.

Зарим төрлийн хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны шүүхүүд хянан шийдвэрлэж эцэслэх хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж Үндсэн хуулийн цэц өмнө (Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 09 дүгээр дүгнэлт) нь шийдвэрлэж байсан нь Улсын дээд шүүхийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг хуулиар тогтоох Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн.

... Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэн, холбогдох тайлбарыг хүргүүлж байна.” гэжээ.

Тав.Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар уг хууль нь Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилттой бөгөөд энэ хүрээнд тус хуулийн 25 дугаар зүйлд Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг (чиг үүрэг) хуульчилжээ.

Ингэж хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг хэвээр хадгалснаас гадна Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно гэж заасны дагуу “шүүхийн шийдвэр нэгдмэл байх” зарчмыг Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд бэхжүүлж өгснөөрөө урьд өмнөх шүүхийн тухай хуулиудтай харьцуулахад үзэл баримтлалын болоод зарчмын хувьд дэвшилттэй болсон төдийгүй дэлхий нийтээр түгээмэл хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл, сайн туршлагад нийцсэн билээ.

Дэлхий нийтээр түгээмэл хүлээн зөвшөөрсөн ойлголтын хүрээнд авч үзвэл аливаа улсын Дээд шүүх нь хоёр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдгээрээ анхан болон давж заалдах шатны шүүхээс ялгагддаг.



Тэдгээр хоёр чиг үүргийг тухайлан дурдвал, шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг хангуулах (хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах) болон эрх зүйг хөгжүүлэх явдал юм. Энэхүү үзэл баримтлал, зарчмыг Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хангаж өгчээ. Тодруулбал, Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.” гэж, улмаар энэхүү зарчмыг бодитоор хэрэгжүүлэх механизмыг нь бүрдүүлэхийн тулд мөн зүйлийн 25.7.5 дахь заалтад “Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх.” гээд 25.7.5.а-д “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, 25.7.5.б-д “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;”, 25.7.5.в-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.” гэж тус тус зааж өгсөн байна.

1. Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулиар бэхжүүлэн хамгаалсан иргэний эрхийг ямар нэг хэлбэрээр хязгаарласан (дордуулсан), хориглосон гэж үзэх үндэслэл байхгүй болно. ...

2. Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэсний “зөрүүг арилгах”, “зөрүүтэй хэрэглэсэн” гэдгийг ойлгохдоо шүүхүүдийн материаллаг болон процессын хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг ойлгох бөгөөд мэдээлэл гаргагч нарын бичээд буй шиг “анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээвэл Улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргах боломжгүй болно” гэсэн үг биш юм.

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал эцсийн шийдлийн хувьд адил ч гэлээ үндэслэж буй хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэх явдал зөрүүтэй байж болно. Энэ тохиолдолд хяналтын шатны шүүх тухайн зөрүүтэй хэрэглэсэн эрх зүйн хэм хэмжээний бүтэц дэх урьдчилсан нөхцөл буюу бүрэлдэхүүн хэсгүүдийг

(гипотез, диспозици, санкци) зөв задлан шинжилж, тайлбарлан хэрэглэсэн эсэхийг хянах замаар хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг арилгаж, шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг тогтооно.

3.Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэснийг зөрчсөн гэж үзэх нь үндэслэлгүй юм. Учир нь эрх зүйн ерөнхий онолын үүднээс авч үзвэл эрх зүйн хэм хэмжээний албан ёсны тайлбарт хуулийн аутентик тайлбараас гадна Улсын дээд шүүхийн тайлбар хамаарна. Албан ёсны шинж гэдэг нь тухайн тайлбарын заавал биелэгдэх шинжийг илэрхийлдэг. Шүүгч хуульд захирагдах хэдий ч хууль тогтоогчийн баталсан бүх хууль эрх зүйн хийдэлгүй, ойлгомжтой буюу тодорхой байдаггүй тул түүнийг тодорхой хэрэг, маргаанд хэрхэн зөв ойлгон хэрэглэх, хийдэлтэй орон зайг хэрхэн нөхөх зэрэг асуудлыг Улсын дээд шүүх тайлбараараа төлөвшүүлэх нь эргээд тухайн шүүгчийн хараат бус байдалд эерэг нөлөө үзүүлэх (онол-практикийн маргаантай хуулийг буруу хэрэглэхээс сэргийлэх, хуулийг алдаа мадаггүй тайлбарлан хэрэглэснээр шүүхэд итгэх нийгмийн итгэл хамгаалагдах гэх мэт)-ээс гадна “эрх зүй тодорхой, тогтвортой байх” зарчмыг хангаж, шударга ёс, хууль ёс амьдралд саадгүй хэрэгжих нэг баталгаа болдог гэдгийг дэлхий нийтээрээ нэгэнт хүлээн зөвшөөрсөн болно.

Энэ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэж Монгол Улсын дээд шүүхийн үндсэн бүрэн эрх байхаар баталгаажуулж, улмаар түүнийг заавал биелүүлэхийг тогтоожээ. ...” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүх давж заалдах шатны



шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.” гэж заасан бөгөөд мөн зүйлийн 25.7.5 дахь заалтад “Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:” гээд 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;”, 25.7.5.в дэд заалтад “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.” гэж хуульчлан хяналтын шатны шүүхийн чиг үүргийн зорилгыг тодорхойлж, хяналтын журмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тохиолдлыг заажээ.

Улмаар дээрх хуульд нийцүүлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна.

2.Гэхдээ Улсын дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн”, “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” тохиолдолд хянан шийдвэрлэхээр хуульчилсан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгыг бүрэн хангаагүй, хэргийн оролцогчдын хяналтын шатны шүүхэд хандах боломжийг хязгаарласан байна. Тодруулбал, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулсан бусад тохиолдлуудыг Улсын дээд шүүх хянах боломжгүй болгон явцууруулж хуульчилсан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хөндсөн байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хууль болон эрүү, иргэн, захиргааны процессын хууль хоорондын уялдааг хангах хүрээнд шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хязгаарласан эрх зүйн хийдлийг арилгах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль

хэрэглээний зөрүүг арилгах,” 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ...”; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалт; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, мөн хуулийн 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг нь иргэдийн мэдээлэлд дурдсан Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”, 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”; мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх,



...”; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;”, 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж тус тус заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

Г.ТУУЛХҮҮ

Ц.НАНЗАДДОРЖ

Г.БАЯСГАЛАН

Д.ГАНГАБААТАР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.25

Индекс: 200003